

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

-
1. ***“Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын
хорооны тогтоолын төсөл*** 3-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
07 дугаар сарын 09-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл-2**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 58.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 38 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан О.Батнайрамдал, П.Ганзориг, Б.Жавхлан, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, М.Мандхай, Б.Найдалаа, Р.Сэддорж, С.Цэнгүүн.

Нэг. “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийг, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалыг, Инновац, цахим хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарыг, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгыг нэр дэвшүүлэв.

Нэр дэвшигчдийн танилцуулга болон нэр дэвшигчидтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Монгол Улсын Их Хурлын Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэлийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 4
Бүгд: 20
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдалыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 2
Бүгд: 20
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим хөгжлийн дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 3
Бүгд: 20
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Б.Уянгыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 3
Бүгд: 20
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Бат-Эрдэнэ: “Дэд хорооны дарга нарыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 2
Бүгд: 20
90.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, ирвэл зохих 31 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
12 цаг 10 минут.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ-2

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүдийнхээ амар амгаланг айлтгая. Ингээд хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Чинбаатарын Анар гишүүн ирсэн байна. Ренчиндоржийн Батболд ирсэн байна. Шинэбаярын Бямбасүрэн ирсэн байна. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн байна. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн ирсэн байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн ирсэн байна. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн ирсэн байна. Батбаярын Жаргалан гишүүн ирсэн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ирсэн. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн. Ирц 31 гишүүнээс 18 гишүүн ирж, 58,1 хувьтай болсон байна.

Ирц бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 7 сарын 9-ний өдрийн хуралдааныг эхлүүлъя. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

“Дэд хороодын даргыг сонгох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүд, асуулт болон саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Дэд хороодын дарга нарыг сонгох тухай асуудлыг хэлэлцье.

Ингээд дэд хороодын дарга нарыг дэвшүүлсэн талаар нам, эвслийн бүлгүүдийн саналыг уншиж танилцуулъя.

Монгол Ардын намын бүлгийн даргын хувьд танилцуулгыг уншиж та бүхэнд танилцуулъя.

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо, Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо, Инновац, цахим хөгжлийн дэд хороодын дарга нарын танилцуулгыг нэг мөр уншиж танилцуулъя.

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргад Нацагдоржийн Батсүмбэрэлийг нэр дэвшүүлж байна.

Нацагдоржийн Батсүмбэрэл нь 1983 онд Баянхонгор аймагт төрсөн. Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг. 2001 онд Баянхонгор аймгийн 2 дугаар дунд сургууль, 2006 онд МУБИС-ийг Түүх, нийгмийн ухааны багш мэргэжлээр төгссөн. 2008 онд МУБИС-д магистр зэрэг хамгаалсан. 2024 онд Монгол Улсын Боловсролын их сургууль Улс төрийн ухааны докторын зэрэг хамгаалсан.

2006-2007 онд Нийслэлийн МАН-ын хороонд улс төрийн ажилтан, 2007 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт референт, 2007-2010 онд

Нийслэлийн МАН-ын хороонд Улс төрийн ажилтан, 2010-2011 онд НАМОХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2011-2012 онд МҮХАҮТ-д Гишүүнчлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, 2012 оноос МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх, 2012-2013 онд Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч, 2013-2016 онд МАН-ын Нам байгуулалт, улс төрийн газарт Улс төрийн бодлогын ахлах ажилтан, 2016-2018 онд “Монгол наадам цогцолбор” Орон нутгийн өмчит төрийн үйлчилгээний газрын дарга, 2018-2020 онд МАН-ын Улс төрийн бодлогын газрын дарга, 2008-2012 онд Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, 2020 оноос НИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, МАН-ын бүлгийн дарга, 2020 оноос НИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, 2020-2024 онд НИТХ, Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг дарга, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2024 оноос Монгол-Унгарын парламентын бүлгийн дарга, Монгол-Австралийн парламентын даргаар ажиллаж байна.

Нацагдоржийн Батсүмбэрэлийн ажлын туршлага, төрийн албанд ажилласан мэдлэг, ур чадварыг нь харгалзан үзсэний үндсэн дээр Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргад Отгоншарын Батнайрамдалыг нэр дэвшүүлж байна.

Отгоншарын Батнайрамдал нь Ховд аймгийн Жаргалант сумд төрсөн. 1998 онд Ховд аймгийн 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 2001 онд Монгол-Туркийн хамтарсан сургууль, 2004 онд Нортикийн дэлхийн нэгдсэн коллеж, 2008 онд Макалестер коллеж Эдийн засгийн бакалавр, 2018 онд Харвардын Бизнесийн сургууль Бизнесийн удирдлагын магистр. 2021-2022 онд Оксфордын их сургууль болон АНУ-ын Колумби Их сургуулийн Байгалийн баялгийн удирдлагын хөтөлбөр, 2025 онд АНУ-ын Харвардын Кеннедигийн сургууль 21 дүгээр зууны дэлхийн манлайлал ба нийтийн бодлого хөтөлбөрт хамрагдсан байна.

2009-2010 онд Чоно корпорацад Хөрөнгө оруулалтын менежер, 2011-2013 онд Ориг Партнерс Монголиа компанид Уул уурхай, хөрөнгө оруулалт хариуцсан Дэд ерөнхийлөгч, 2015-2017 онд АНУ-ын Банк оф Америка Нью-Йорк болон Сидней дэх салбарт Уул уурхайн хөрөнгө оруулалтын банкир, 2018 онд Эрдэнэс Тавантолгой ХК-д IPO, Хувьцаа хариуцсан дэд захирал, 2019-2020 онд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, 2020-2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн Дэд сайд, 2022 оноос МАН-ын Бага хурлын гишүүн, 2023-2024 онд МАН-ын Нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдалын ажлын туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг харгалзан Улсын Их Хурлын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны даргад Чинбаатарын Анарыг нэр дэвшүүлж байна.

Чинбаатарын Анар нь 1982 онд төрсөн. Эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг. 1995 онд Хэнтий аймгийн Бэрх тосгоны сургуульд суурь боловсрол эзэмшсэн. 1998 онд Өвөрхангай аймгийн 2 дугаар 10 жилийн сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн. 2001-2005 онд “МЦХ” ХХК-д системийн инженер, 2004-2006 онд “Нэтсофт” ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд гүйцэтгэх захирал, 2006-2009 онд Жи

Мобайл ХХК үүсгэн байгуулагч, техникийн газрын захирал, Бизнес хөгжлийн захирал, 2009-2011 онд "СисТелком" ХХК-д захирал, "Иромакс" ХХК-д захирал 2011- 2015 онд "АПГО Лимитед" төслийн удирдагч, 2015-2017 онд "АНД Системс" ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, 2016 оноос "Лэндмн" ББСБ ХК, Үүсгэн байгуулагч, 2017-2019 онд "Анд Глобал Пти" ЛТД үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, 2018-2024 онд "Ирбис Венчурс Пти" ЛТД- Үүсгэн байгуулагч, Ерөнхийлөгч, 2020-2022 онд Монголын Математикийн Олимпын хорооны Ерөнхийлөгч, 2022 оноос онд "Ондо спэйс" ХХК Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, 2023-2024 онд "Ондо" ХХК Үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн дарга, 2021-2024 онд "Андореан" ХХК Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал, 2022-2024 онд "Ондо Холдинг" ХХК Үүсгэн байгуулагч, УЗ-ийн дарга, 2024-нд "Ондо спэйс академи" ТББ Үүсгэн байгуулагч, УЗ-ийн даргаар ажиллаж байсан. 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.

Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарыг ажлын туршлага, ур чадварыг нь харгалзан үзсэний үндсэн дээр Инновац, цахим бодлогын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад Болдын Уянгыг нэр дэвшүүлж байна.

Болдын Уянга нь 1986 онд Улаанбаатар хотод төрсөн. Нөхөр, 3 хүүхдийн хамт амьдардаг. 2003 онд АНУ-ын Ватертаун ахлах сургууль, 2007 онд ШУТИС-ийн Геологи, газрын тосны сургууль, геологийн инженер, бакалавр, 2010 онд ШУТИС-ийн Геологи, газрын тосны сургууль, геологийн инженер, магистр, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуулийн Байгалийн ухааны доктор.

2007-2010 онд Рио Тинто Монгол ХХК-д судлаач, геологич, 2016-2018 онд Япон улсын Токиогийн их сургуулийн Шинжлэх ухаан, одон орны судлалын тэнхимд судлаач, 2019-2020 онд Шинжлэх ухаан, техникийн их сургуулийн Судалгаа инновацын тэнхимд лектор, 2020-2022 онд Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албанд Дэд дарга, Ерөнхий геологич, 2022-2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Геологийн бодлогын газрын дарга, 2023 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын зөвлөх, 2024 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн Дэд сайд, 2024 оноос Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүнээр тус тус ажиллаж байна.

Болдын Уянгын ажлын туршлага, мэдлэг, ур чадварыг харгалзан үзсэний үндсэн дээр Улсын Их Хурлын Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргад нэр дэвшүүлж байна.

Дэд хороодын дарга нарыг нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Санал хураалт явуулъя.

Саналын томъёолол. Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэлийг сонгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 16 гишүүн оролцож, 80 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдалыг сонгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 18 гишүүн оролцож, 90 хувиар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарыг сонгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 17 гишүүн оролцож, 85 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгыг сонгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 17 гишүүн оролцож, 85 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны тогтоол. “Дэд хорооны даргыг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.10, 27.11 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэг, санал хураалтын дүнг тус тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь.

1.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Нацагдоржийн Батсүмбэрэлийг сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Отгоншарын Батнайрамдалыг сонгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Цахим, инновац цахим бодлогын хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чинбаатарын Анарыг сонгосугай.

4.Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянгыг сонгосугай.

Ингээд дэд хорооны дарга нар сонгогдсонтой холбогдуулан “Дэд хорооны даргыг сонгох тухай” Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 20 гишүүнээс 18 гишүүн оролцож, 90 хувиар санал дэмжигдлээ.

“Дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Тогтоол батлагдлаа.

Хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул Эдийн засгийн байнгын хорооны хурал өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

16.53 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ